

ЖАЙКА-ийн Монгол дахь Төлөөлөгчийн газрын мэдээллийн хуудас. 2018 оны 4 сарын дугаар

Тэргүүн Мэдээ

Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдлын тухай сургалтыг (DET) идэвхтэй зохион байгуулж байна.



Сургагч багш бэлтгэх сургалтанд хамрагдагсад

Техникийн хамтын ажиллагааны “Улаанбаатар хот дахь Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог дэмжих төслийн” хүрээнд хэрэгжүүлж буй Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдлын тухай сургалт (DET) нь нийгэм дэх “Бэрхшээлийг” олж илрүүлэн, шийдвэрлэхэд чиглэсэн үйл ажиллагааг бодож олох Workshop хэлбэрийн сургалт бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй иргэд өөрсдөө сургагч багшийн үүрэг гүйцэтгэдэг юм. 2016 оны 12 сард Монгол улсад анх удаа сургагч багш бэлтгэх сургалт явагдаж анханы 16 сургагч багш бэлтгэгдсэн юм. Түүнээс хойш хөгжлийн бэрхшээл ба тэгш байдлын тухай сургалтыг (DET) 150 гаруй удаа зохион байгуулж, оролцогчдын тоо 5000 давсан байна. 4-р сард сургагч багш бэлтгэх 2 дахь удаагийн сургалт болж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр өргөн сурталчилсан нь, олон нийтийн анхаарлыг ихэд татсан бөгөөд цаашид уг сургалтын хамрах хүрээг улам өргөжүүлэхийг зорьж байна.

Улс төр, эдийн засгийн чиг хандлага

Ерөнхий сайд У.Хүрэлсүх Хятад улсад айлчлав.

4 сарын 8-аас 12-ний өдөрт ерөнхий сайд У.Хүрэлсүх засгийн газрын гишүүдийн хамт Хятад улсад албан ёсоор айлчлав. Айлчлалын үеэр Хятад улсын төрийн зөвлөлийн ерөнхий сайд Ли Көцянтэй хэлэлцээр хийж, Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламжийг шинэчлэн барих тухай хэлэлцээр зэрэг 11 хэлэлцээрт (нийт дүн 4.5 тэрбум ам.доллар) гарын үсэг зурав. Монгол улсын экспортын 80% нь Хятад улсад ногдох бөгөөд эдийн засгийн хүчтэй харилцаа холбоотой хоёр улсын харилцаа цаашид яаж явах нь анхаарал татаж байна.

Төслийн хэрэгжилт

Япон Монголын сургалтын эмнэлгийн удирдлага болон тусламж үйлчилгээний менежментийг сайжруулах төслийн хүрээнд Япон улсад сургалт зохион байгуулав.



Токушимагийн Их сургууль дээрх сургалт

Буцалтгүй тусламжийн хүрээнд барьж буй АШУҮИС-ийн сургалтын эмнэлгийн үйл ажиллагааны бүтэц зохион байгуулалтыг бий болгох үүднээс ТХА-ны “Япон Монголын сургалтын эмнэлгийн удирдлага болон тусламж, үйлчилгээний менежментийг сайжруулах төсөл” –ийг хэрэгжүүлж байна. 2-3 дугаар сард эмнэлгийн мэдээллийн систем, дотоод халдварын эсрэг арга хэмжээ гэсэн сэдвээр Японы Токушима болон Эхимэ их сургууль дээр зохион байгуулагдсан сургалтанд АШУҮИС-ийн эмч багш нарын нийт 17 хүн оролцлоо. Энэхүү сургалтаар эмнэлгийн үйл ажиллагаа хариуцсан ажилтан бэлтгэх болон бүтэц, тогтолцоог хэрхэн бий болгох туршлагаас суралцаж эмнэлгийн үйл ажиллагааг эхлүүлэхэд чиглэсэн бэлтгэлийг хангах юм.

ТХА “Газар хөдлөлтийн гамшгийн эрсдлээс сэргийлэх чадавхийг бэхжүүлэх төслийн” хамтарсан зохицуулах хорооны 5 дугаар хуралдаан болов.



Хамтарсан зохицуулах хорооны хурал

4 сарын 23-ны өдөр ТХА “Газар хөдлөлтийн гамшгийн эрсдлээс сэргийлэх чадавхийг бэхжүүлэх төслийн” хамтарсан зохицуулах хорооны 5 дугаар хуралдаан болж, Монголын анханы гамшгийн эрсдлээс хамгаалах цагаан номны эхийг боловсруулах, ОБЕГ болон Эрүүл мэндийн яамны хооронд гамшгийн үед хамтран ажиллах санамж бичиг байгуулахаар бэлтгэл ажил явагдаж байгаа зэрэг тодорхой үр дүнг тайлагнав. Улаанбаатар хотноо 7 сард болох Гамшгийн эрсдэлийг бууруулах Азийн сайд нарын бага хурлын үеэр эдгээр ажлын үр дүнгээ олон нийтэд таниулан тайлагнахын тулд Япон болон Монгол хоёр талын төсөл хэрэгжүүлэгчид үргэлжлүүлэн идэвхтэй хамтран

ажиллахаар Хамтарсан зохицуулах хорооны хуралдааны үеэр харилцан тохиролцов.

Генийн өөрчлөлттэй хүнс болон хүнсний нэмэлтэд шинжилгээ хийх чадавхийг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлж байна.



Нагоя хотын эрүүл ахуйн хүүрээлэн дээр туршилт хийж буй нь

2018 оны 3 сард “Хүнсний аюулгүй байдлыг хангах, молекул биологийн болон хүнсний нэмэлтэд хийх шинжилгээний ур чадварыг дээшлүүлэх ” сэдэвт хаалтын сургалт Япон улсад зохион байгуулагдлаа.

Импортын хүнсний бүтээгдэхүүнээс хамааралтай манай улсад хүнсний бүтээгдэхүүнд шинжилгээ хийх тогтолцоог сайжруулах зорилт тулгараад байна. Генийн өөрчлөлттэй хүнс, хүнсний нэмэлтэд шинжилгээ хийх шинжээчдийн ур чадварыг дээшлүүлэх зорилготой энэхүү сургалтанд Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн 20 шинжээч хамрагдаж, Нагоя хотын эрүүл ахуйн хүүрээлэн дээр шинжилгээний арга зүйд суралцав. Сургалтанд хамрагдагсад эх орондоо буцаж ирсэний дараа өөрсдийн санаачлагаар төвийн болон орон нутгийн шинжээчдийг хамруулсан сургалт зохион явуулж, сургалтын үр дүнг түгээхэд хувь нэмэр оруулж байна.

Сайн дурын үйл ажиллагаа

Сайн дурын үйл ажиллагааны танилцуулга (Боловсролын бүлгэм дэд хороо)



Үзүүлэх хичээл зааж буй бага ангийн сайн дурын багш Киккава Кэнго

3 сарын 13-ны өдөр Улаанбаатар хотын Багануур дүүрэгт Боловсролын салбарт ажиллаж байгаа сайн дурын гишүүдийн бүлгэм семинар зохион байгуулав. Семинарт Багануур дүүргийн 30 багш оролцсон. Семинарын зорилго нь Боловсролын бүлгэмийн сайн дурын гишүүд байгалийн ухаан болон математик, зургийн хичээлийг “Хүүхэд төвтэй” хэлбэрээр зохион байгуулах аргачлалын талаар үзүүлэх хичээл явуулсан бөгөөд багш нар ихэд шимтэн сонсож байлаа. Багшийн мэргэжлээр ажиллаж байгаа Боловсролын бүлгэмийн сайн дурын гишүүд Япон багш нарын заах арга зүй болон өөрсдийн мэдлэг, туршлагыг зааж таниулсан. Цаашид ч Монголын багш нарт тулгарч буй асуудлуудыг шийдвэрлэхэд өөрсдийн хувь нэмэрээ оруулахаа хэлж байв.



ЖАЙКА-ийн Сургалт төгсөгчдийн холбоо

2017 оны “Шилдэг туршлага нэвтрүүлэгч”-дээс танилцуулж байна. “Хүнсний аюулгүй байдлын удирдлага”



Б.Алтантуяа даргын зохион байгуулсан семинарын явц танилцуулга хийж байгаа нь

2015 оны 10 дугаар сард ЖАЙКА-ийн Кюүшү дэх сургалтын төвд зохион байгуулагдсан “Хүнсний аюулгүй байдлын удирдлага” сэдэвт сургалтанд хамрагдсан Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын Хан-Уул дүүрэг дэх Мэргэжлийн хяналтын хэлтсийн дарга Б.Алтантуяа эх орондоо эргэж ирснээс хойш Япон улсад сурсан мэдсэнээ ашиглан хүнсний аюулгүй байдлын чиглэлээр нийт 21 удаагийн сургалт семинар, хэлэлцүүлэг зэргийг зохион байгуулж, ойролцоогоор 5000 гаруй хүнд сургалтын ноу хауг түгээж чадсан байна. Түүний энэхүү идэвхитэй, тасралтгүй үйл ажиллагаа явуулж ирсэн хүчин чармайлтыг өндөрөөр үнэлэн ЖАЙКА-ийн Сургалт төгсөгчдийн холбооны 2017 оны “Шилдэг туршлага нэвтрүүлэгч”-ээр шалгарууллаа.

発行：JICA モンゴル事務所

Bodi Tower 7th Floor, Sukhbaatar Square 3, Ulaanbaatar

Tel : +976-325939, 311329 / Fax : +976-310845 / E-mail : mg_oso_rep@jica.go.jp